

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

АГУУЛГА

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БНБД	Монгол Улсын Барилгын норм ба дүрмүүд
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАР ХОТЫН ОЛОН
УЛСЫН НИСЭХ ОНГОЦНЫ ШИНЭ
БУУДАЛ БАРИХ ТӨСЛИЙН ЗАХИРАЛ
Н.ЭНХБАТ ТАНАА

2020.02.27 № 06/627
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөлд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Н.Энхбат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Тайлант хугацаанд Агаарын хөлгийн засвар, үйлчилгээний барилгыг барьж дуусгасантай холбогдуулан 2020 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн Барилга, хот байгуулалтын сайдын 32 дугаар тушаалаар Улсын комисс хөрөнгө хүлээлцэх шатандаа явж байна. Иймд “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 26 дугаар зүйлийн 26.1.1-д “гэрээ, хэлэлцээрт заасан төсөл хэрэгжих хугацаа дуусгавар болж, ажлууд бүрэн хэрэгжсэн” гэж заасны дагуу төслийн үйл ажиллагаа дуусвар болж байгаатай холбогдуулан тайлант хугацаанд санхүүгийн аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 05-наас 2020 оны 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөж, “Тэд-Аудит” ХХК-ийн ерөнхий захирал Ц.Сугармаа, аудитор Г.Эрдэнэчимэг, аудиторын туслах Э.Сайнзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 014 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь УБ хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг иж бүрэн цогцолбороор барьж байгуулахад оршино.

Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шинэ нисэх буудлын барилга байгууламжуудыг олон улсын стандарт, Монгол Улсын Барилгын норм ба дүрмүүд (БНБД) дүрэмд нийцүүлэн чанартай барьж байгуулах;
- Гадаадын зээл, улсын төсвийн хөрөнгө оруулалтыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acoulous 3.0 программ хангамж ашигладаг байна.

Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 774,841.4 мянган төгрөгөөс 2.0 хувиар тооцон 15,496.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшний тооцоололд өөрчлөлт ороогүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 115,727,293.6 мянган төгрөгөөр буюу 10.4 хувиар өссөн байна.

Энэ нь тайлант жилд зээлийн хөрөнгөөр Ангарын барилгын ажлыг барьж гүйцэтгэхэд гарсан нийт зардал 115,727,293.6 мянган төгрөг дуусаагүй барилга дээр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөг)			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,505.2	0	(5,505.2)
Бараа материал	675.0	500.0	(175.0)
Үндсэн хөрөнгө	554,858.7	292,563.0	(262,295.7)
Биет бус хөрөнгө	102.7		(102.7)
Дуусаагүй барилга	1,113,219,901.2	1,229,215,273.4	115,995,372.2
Нийт хөрөнгө	1,113,781,042.8	1,229,508,336.4	115,727,293.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,113,781,042.8	1,229,508,336.4	115,727,293.6

Үндсэн хөрөнгө буурсан нь ТӨБЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 431 дугаар тогтоолоор 135,100.0 мянган төгрөгийн үнэтэй, жижиг оврын 2 ширхэг автобусыг “Авто Тээврийн Үндэсний Төв” ТӨҮГ болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт шилжүүлсэн, мөн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалд 127,196.0 мянган төгрөгийг хасч элэгдлийн зардалд бүртгэсэн байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 675.0 мянган төгрөг байснаас жилийн эцэст 500.0 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй болсон бөгөөд энэ нь шатахууны үлдэгдэл байна. Энэ нь Сангийн яамны Төрийн сангийн гүйлгээ дунджаар 1 дүгээр сарын 10-ны өдрөөс эхэлж явагддаг тул шатахууны зардлыг нөөцөлж авч үлдсэнтэй холбоотой байна.

Дуусаагүй барилгын эхний үлдэгдэл 1,113,210,901.2 мянган төгрөг байсан бөгөөд тайлант жилд 115,727,293.6 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал нэмж гарсантай холбоотой.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд 845,100.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 774,841.4 мянган төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 91.7 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 774,841.4 мянган төгрөг буюу 91.7 хувьтай байгаа нь эхний үлдэгдэл 5,505.2 мянган төгрөг, зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 70,258.5 мянган төгрөг нийт 75,763.8 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд цалинд 653,437.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 80,932.1 мянган төгрөг, хангамжийн материалд 30,635.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 9,835.9 мянган төгрөг буюу нийт 774,841.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 75,763.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 5 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 0 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төсөл хэрэгжих хугацаа дуусгавар болж байгаатай холбогдуулан Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 26.1.1, 26.1.2, 26.2-т заасны дагуу төслийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн дүгнэлт, төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч байгууллагад шилжүүлсэн байдал, ажлын гүйцэтгэл зэрэгт анхаарах нь зүйтэй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсөв, гүйцэтгэлийн 8, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5, бусад 6 нийт 19 төрлийн мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Нийт 1 зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,180,279.83	500,000.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,505,279.83	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	5,505,279.83	-
3121	Төгрөг	5,505,279.83	-
31211	Төрийн сангийн харилцах	5,505,279.83	-
35	БАРАА МАТЕРИАЛ	675,000.00	500,000.00
354	Хангамжийн материал	675,000.00	500,000.00
35440	Түлш, шатах тослох материал	675,000.00	500,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,113,774,862,582.18	1,229,507,836,470.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,113,774,862,582.18	1,229,507,836,470.46
392	Биет хөрөнгө	554,858,742.54	292,563,076.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,325,810,000.00	1,190,710,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(775,822,583.17)	(900,280,083.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	57,066,765.00	57,066,765.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(54,235,331.85)	(54,933,605.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,366,533.00	33,366,533.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,326,640.44)	(33,366,533.00)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	1,113,219,901,172.80	1,229,215,273,393.94
393	Биет бус хөрөнгө	102,666.84	-
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(667,333.16)	(770,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,113,781,042,862.01	1,229,508,336,470.46
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,113,781,042,862.01	1,229,508,336,470.46
51	Засгийн газрын хувь оролцоо	1,113,781,042,862.01	1,229,508,336,470.46
512	Хуримтлагдсан үр дүн	1,113,781,042,862.01	1,229,508,336,470.46
51210	Өмнөх үеийн үр дүн	1,113,781,042,862.01	1,113,781,042,862.01
51220	Тайлант үеийн үр дүн		115,727,293,608.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,113,781,042,862.01	1,229,508,336,470.46

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөг/	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	42,152,990,194.66	116,840,472,221.14
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	789,208,480.00	845,100,000.00
122	Тусламжийн орлого	789,208,480.00	845,100,000.00
122005	Төсвөөс санхүүжих санхүүжилт	789,208,480.00	845,100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	41,363,781,714.66	115,995,372,221.14
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	41,363,781,714.66	115,995,372,221.14
131005	Хөрөнгийн санхүүжилт	41,363,781,714.66	115,995,372,221.14
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,041,674,117.41	1,062,403,334.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,041,674,117.41	1,062,403,334.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,041,674,117.41	986,639,540.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	692,930,614.53	653,437,809.00
210101	Үндсэн цалин	692,930,614.53	653,437,809.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,305,307.47	80,932,058.51
210201	Тэтгэврийн даатгал	55,408,538.00	55,398,564.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,990,868.00	6,922,281.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,540,854.00	5,213,982.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,332,093.47	1,217,929.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,032,954.00	12,179,302.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,903,037.91	30,810,687.58
210401	Бичиг хэрэг	4,956,920.00	8,564,970.00
210402	Тээвэр, шатахуун	16,062,205.00	16,487,049.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,883,912.91	5,758,668.08
2107	Томилолт, зочны зардал	1,903,360.00	
210701	Гадаад албан томилолт	1,903,360.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,816,700.00	9,835,930.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,816,700.00	6,835,930.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	233,815,097.50	211,623,055.12
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	233,815,097.50	211,623,055.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		75,763,794.74
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг		75,763,794.74
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		75,763,794.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	41,111,316,077.25	115,778,068,886.19
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	70,380,833.35	50,775,277.74
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	70,380,833.35	50,775,277.74
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(70,380,833.35)	(50,775,277.74)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	41,040,935,243.90	115,727,293,608.45

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	789,208,480.00	845,100,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	789,208,480.00	845,100,000.00
122	Тусламжийн орлого	789,208,480.00	845,100,000.00
122005	Төсвөөс санхүүжих санхүүжилт	789,208,480.00	845,100,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	808,014,019.91	850,605,279.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	808,014,019.91	850,605,279.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	808,014,019.91	774,841,485.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	693,470,228.00	653,437,809.00
210101	Үндсэн цалин	693,470,228.00	653,437,809.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,765,694.00	80,932,056.42
210201	Тэтгэврийн даатгал	55,158,611.98	57,535,299.58
210202	Тэтгэмжийн даатгал	5,540,854.46	5,130,863.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,657,977.83	5,353,768.96
210204	Ажилгүйдлийн даатгал	1,333,175.13	1,632,411.56
210205	Эрүүл мэндийн даатгал	13,075,074.60	11,279,712.65
2104	Хангамж, бараа материалын зардал	25,058,037.91	30,635,687.58
210401	Бичиг хэрэг	4,956,920.00	8,564,970.00
210402	Тээвэр, шатахуун	16,217,205.00	16,312,049.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,883,912.91	5,758,668.08
2107	Томилолт, зочны зардал	1,903,360.00	-
210701	Гадаад албан томилолт	1,903,360.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,816,700.00	9,835,932.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,816,700.00	6,835,932.09
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	75,763,794.74
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	75,763,794.74
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		75,763,794.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(18,805,539.91)	(5,505,279.83)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(18,805,539.91)	(0.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	24,310,819.74	5,505,279.83
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,505,279.83	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			1,113,781,042,862.01	1,113,781,042,862.01
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			1,113,781,042,862.01	1,113,781,042,862.01
D08	Тайлант үеийн үр дүн			115,727,293,608.45	115,727,293,608.45
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			1,229,508,336,470.46	1,229,508,336,470.46

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант он		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	845,100,000.00	774,841,485.09	70,258,514.91	91.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	845,100,000.00	774,841,485.09	70,258,514.91	91.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	845,100,000.00	774,841,485.09	70,258,514.91	91.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	705,806,725.00	653,437,809.00	52,368,916.00	92.6
210101	Үндсэн цалин	705,806,725.00	653,437,809.00	52,368,916.00	92.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,712,900.00	80,932,056.42	11,780,843.58	87.3
210201	Тэтгэврийн даатгал	63,969,023.82	57,535,299.58	6,433,724.24	89.9
210202	Тэтгэмжийн даатгал	5,548,743.16	5,130,863.67	417,879.49	92.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,095,928.98	5,353,768.96	1,742,160.02	75.4
210204	Ажилгүйдлийн даатгал	1,737,185.82	1,632,411.56	104,774.26	94.0
210205	Эрүүл мэндийн даатгал	14,362,018.22	11,279,712.65	3,082,305.57	78.5
2104	Хангамж, бараа материалын зардал	35,200,000.00	30,635,687.58	4,564,312.42	87.0
210401	Бичиг хэрэг	12,160,000.00	8,564,970.00	3,595,030.00	70.4
210402	Тээвэр, шатахуун	16,329,600.00	16,312,049.50	17,550.50	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,710,400.00	5,758,668.08	951,731.92	85.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,380,375.00	9,835,932.09	1,544,442.91	86.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,380,375.00	6,835,932.09	1,544,442.91	81.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0	75,763,794.74	-	
				75,763,794.74	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	845,100,000.00	845,100,000.00	0.00	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	845,100,000.00	845,100,000.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	845,100,000.00	845,100,000.00	0.00	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		5,505,279.83	-5,505,279.83	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	17	17		
620001	Удирдах ажилтан	2	2		
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14		
620003	Үйлчлэх ажилтан	1	1		

